



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа  
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2025 оны 10-р сар)

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

Тус төв нь төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 10 дугаар сард дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж, иргэддээ төрийн үйлчилгээг хүргэж ажиллав.

## **1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСГИЙН 2025 ОНЫ 10 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

(Тайлант хугацаа: 2025.09.19 - 2025.10.20)

### **1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажлууд**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **278** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 55,406,033 вон, нутаг буцах зардал: 2,937,490 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 9,853,840 вон, нийгмийн хамгааллын чиглэлээр визгүй иргэдэд 4,385,000 воны эмнэлэгийн үнэ төлбөргүй эмчилгээ үйлчилгээ зэрэг нийт **79,791,093** воныг Монгол Улсын **105** иргэнд олгуулав.

### **1.2. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад үзүүлсэн үйлчилгээ**

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Э.Х нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 10,092,355 вон, нутаг буцах зардал 537,000 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.А нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 6,977,170 вон, нутаг буцах зардал 523,500 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Д.Б нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 5,326,361 вон, нутаг буцах зардал 511,000 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.Б нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал 7,229,790 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Р.Л нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал 9,983,157 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Т.Т нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал 3,751,000 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Т.Н нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, нутаг буцах зардал 5,000,000 воныг олгуулав.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.А-гийн үйлдвэрлэлийн осолд бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч хүсэлтийг боловсруулан илгээж, эмчилгээний зардалд 468,570 вон, ажиллаагүй үеийн цалин хөлс 6,740,160 вон, нийт 7,208,730 воныг олгуулсан.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.Э-гийн нутаг буцах зардал 365,990 воныг Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас нэхэмжлэн олгуулсан.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Б.Н-ийн ар гэрт нутаг буцах зардлыг олгуулах хүсэлтийг 근로복지공단 인천 지사-д хүргүүлсэн.

Хөдөлмөрийн гэрээт ажилчин Ц.Т-гийн ажлын байр солих өргөдлийг шийдвэрлэхээр Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Чанвоны Хөдөлмөрийн бирж, Сувоны Хөдөлмөрийн бирж, Хууль зүйн фирм, ажил олгогч болон өргөдөл гаргагчтай удаа дараа холбогдсоноор ажлын байр солих мэдэгдэл нь хийгдсэн тухай 2025.09.18-ны өдөр Чонвоны Хөдөлмөрийн биржээс мэдэгдсэн.

Е-7-4 визтэй иргэдэд баримт бичиг бүрдүүлэлт, орчуулгын туслалцаа үзүүлснээр иргэн Б.У нь визний хугацаагаа сунгасан, иргэн Б.Т нь Солонгосын жолооны үнэмлэх авсан. Мөн тус визтэй иргэн Б.Н-д гэр бүлээ урих, жолооны үнэмлэх авах асуудлаар, Б.М-д виз сунгалт хийлгэх, Я.Д-д ажлын байр солих, D-10 визний нөхцөл, М.О-д гэрээний хугацаа дууссаны дараа ажлын байр солих асуудлаар туслалцаа үзүүлсэн.

Хөдөлмөрийн гэрээт ажилчны Е-9 визээс ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 виз рүү шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 5 иргэнийг, тус виз рүү шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 2 иргэнийг шинээр бүртгэж, нийт 16 иргэнд оноо тоолох, гэр бүлээ урих, хэлний шалгалт сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, виз мэдүүлэгт дэмжлэг үзүүлэв.

### **1.3. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ**

Иргэн Б.Д-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлс нэхэмжилж ажил олгогчтой холбогдсон ч барагдуулаагүй тул өргөдлийн бүрдүүлбэрийг ханган Хөдөлмөрийн хэлтэс (고양고용노동지청)-т өргөдөл гаргаснаар 500,000 вон олгуулав.

Иргэн Б.Т-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлс 3,420,000 воныг олгуулах хүсэлтийг хүлээн авч 중부지방노동지청-д өргөдлийг хүргүүлэн, ажил олгогчтой тохиролцооноор 2,500,000 вон олгуулсан.

Иргэн Ц.Б, С.Ч нарын (E-8) илүү цагийн хөлс олгоогүй асуудлаар Хөдөлмөрийн хэлтэс (충주고용노동지청)-т өргөдлийг гарган, талуудын уулзалтад орчуулагчаар дэмжлэг үзүүлэн ажиллаж 2,777,200 вон олгуулсан.

Иргэн О.С-ийн (G-1) олгогдоогүй цалин 1,376,640 воныг нэхэмжилж харьяа Хөдөлмөрийн хэлтэст өргөдөл гарган шийдвэрлүүлэв.

Иргэн Г.Х-гийн (G-1) нутаг буцах замыг зардал 500,000 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулав.

Иргэн Ц.Г-гийн (визгүй) 2024 оны 10 сард ажиллаад авч чадаагүй цалин 1,700,000 воныг нэхэмжлэн олгуулав.

Иргэн Б.Ж-гийн (визгүй) олгогдоогүй цалингийн үлдэгдэл 1,000,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Б.Г-гийн (визгүй) 13 дахь сарын цалинг олгуулах асуудлаар ажил олгогчтой нь удаа дараа холбогдсон ч тохиролцоонд хүрч чадаагүй тул Хөдөлмөрийн хэлтэс (서울동부고용노동청)-т өргөдөл гаргасан ба 2025.09.25-нд өргөдөл гаргагч өөрийн биеэр очиж мэдүүлэг өгсөн.

Иргэн С.Г-гийн (визгүй) 13 дахь сарын цалинг олгуулах асуудлаар Хөдөлмөрийн хэлтэс (서울남부고용노동지청)-т 2025.09.26-нд өргөдөл гаргасан ба 2025.10.20-нд мэдүүлэг өгөхөөр болсон.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад хууль бус болсон иргэн Д.Ц нь 화성외국인보호소-д саатуулагдсан ба бичиг баримтгүй, буцах зардалгүйн улмаас хандсан. Ар гэр болон Цагаачлалын алба, Самсунг даатгал руу холбогдон асуудлыг шийдвэрлэсэн.

Иргэн Б.Д нарын 7 иргэний (визгүй) 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл барилгын мужааны ажил хийсэн цалин болох нийт 27,600,000 воныг нэхэмжилж Сосан хотын Хөдөлмөрийн хэлтэст өргөдөл гаргасан.

Иргэн Т.Б, Б.П, Л.О, Б.О, Б.Т (визийн зөрчилтэй) нарын олгогдоогүй цалин, ажилласан хугацааны 13 дахь сарын цалин нэхэмжилсэн өргөдлийг харьяа хөдөлмөрийн хэлтэст хүргүүлсэн.

Иргэн Д.Ч, Ч.М (визгүй) нарын олгогдоогүй цалингийн маргааныг шийдвэрлүүлэхээр 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Сөүл хотын хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төвд хүргүүлэн ажилласан.

#### **1.4. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр**

Сөүл хотын “Seoul jump medical center”-тэй хамтарсан эрүүл мэндийн үзлэг оношилгоог 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр, Хинён эрүүл мэндийн байгууллагатай хамтран 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж визгүй оршин сууж буй 77 иргэнийг хамруулан 4,385,000 воны үнэ бүхий эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэж, орчуулгын тусламж үзүүлэв. Энэхүү үйл ажиллагааны явцад нийгмийн даатгалын талаарх холбогдох хууль тогтоомж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн тухай хууль, “Нийгмийн хамгааллын тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн талаар мэдээлэл өгсөн.

ГБХНХЯ-нд гадаадад байгаа иргэдэд тулгарч буй асуудлын талаар “Цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжлэг хүсэх тухай” албан бичгийг боловсруулан хүргүүлсэн.

ХХҮЕГ-т ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээ, орлого багатай өрх, онцгой нөхцөлд үзүүлэх тусламж, тэтгэмж, нөхөн олговор, цахим үйлчилгээ зэрэг сэдвийн хүрээнд сургалт авах хүсэлтийг албан бичгээр хүргүүлж, 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр цахим сургалт зохион байгуулсан.

#### **1.5. Сэтгэл зүйн чиглэлээр иргэдэд үзүүлсэн үйлчилгээ**

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн иргэдийн сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор судалгаа зохион байгуулж үр дүнгийн талаар дүгнэлт гаргаж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ганцаарчилсан сэтгэл засал болон сэтгэл зүйн зөвлөгөөг нийт 35 иргэнд өгч ажиллав. Түүнчлэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн 41 иргэнийг сэтгэлзүйн сорилд хамруулсан.

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн  
2025 оны 10 дугаар сард гүйцэтгэсэн  
ажлын тайлан (хүснэгтээр)**

Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо

д/д	Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
			Иргэн	Олгуулсан дүн (вон)
1	Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	Нутаг буцах зардал	6	2,937,490
2		Цалин, илүү цагийн хөлс		
3		Самсунгийн 13 дахь сарын цалин	8	55,406,033
4		Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	1	
5		Үйлдвэрлэлийн ослын даатгал	1	7,208,730
6		Гэнэтийн ослын даатгал		
7		Гэнэт халагдсаны тэтгэмж		
8		Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
9	Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	5	6,853,840
10		13 дахь сарын цалин		
11		Үйлдвэрлэлийн ослын даатгал		
12		Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
13	Хууль бусаар оршин суудаг иргэдэд	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	6	3,000,000
14		13 дахь сарын цалин	1	
15		Үйлдвэрлэлийн ослын даатгал		
16		Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	77	4,385,000
<b>Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн</b>			<b>105</b>	<b>79,791,093</b>

Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
59	25	21	18	-	20

Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

1	Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	25	
2	Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	12	
3	Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлэх	16	
4	Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	21	
5	Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	5	
6	Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	2	
7	Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах		
8	Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр солих болон гэнэт халагдсан тохиолдолд бүрдүүлэх материал, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлэх	4	
9	Хөдөлмөрийн гэрээ сунгах /1жил 10сар/, тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	1	
10	Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага, Хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, Төв бирж, Эрүүл мэндийн газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Үндэсний тэтгэврийн алба, Хөдөлмөр, халамжийн газар /Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга/	35	
11	Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал /ЭМД, ГОД, ҮОД, НД/-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	3	
12	Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх		
13	Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар /ХЭХЯ/, Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлэх		
14	Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах		
15	Визний ангилал солиулахад /Е9-өөс Е-7-4 виз рүү/ оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	16	
16	Бусад мэдээлэл, зөвлөгөө	133	
17	ХурДан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх	5	
Үзүүлсэн үйлчилгээний тоо		Утсаар	233
		Цахимаар	16
		Танхимаар	29
		<b>Нийт</b>	<b>278</b>

## **2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСГИЙН 2025 ОНЫ 10 ДУГААР САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

(Тайлант хугацаа: 2025.10.01 - 2025.10.31)

### **2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд**

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс: 11 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 18 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 4 иргэнд гэж үрэгдүүлсний улмаас дахин олгосон;
- 8 иргэнд шинээр гэрчилгээ олгосон;

Нийт 30 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс: 26 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 15 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 8 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 21 иргэнд шинээр гэрчилгээ олгосон;

Нийт 44 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

### **2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд**

Тайлант хугацаанд тус тасаг 236,204,524.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 56 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 236,204,524.00 төгрөгийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2025 оны 10 дугаар сард нийт 88 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 44,032,302 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 24 даатгуулагчийн 15,104,000.00 төгрөг, сайн дурын даатгалын 64 даатгуулагчийн 28,928,302.00 төгрөг байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 1 ээлжийн 4 иргэний 30,730,640 вон нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн.

### 2.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

1) 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү, Ичон хот дахь Олон улсын сургалтын төвд E-9 визний ангиллаар барилга, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирж буй 73 хөдөлмөрийн гэрээт ажилчдад ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж, Монгол Улсын нийгмийн даатгалын талаарх холбогдох хууль тогтоомж, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн тухай хууль, “Нийгмийн хамгааллын тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн талаар мэдээлэл өгсөн.

2) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг утас, цахим, танхимаар нийт 168 иргэн, даатгуулагчид үйлчилгээг үзүүлсэн.

Нийгмийн даатгалын тасгийн  
2025 оны 10 дугаар сард гүйцэтгэсэн  
ажлын тайлан (тоон дүнгээр)

№	Үйлчилгээ	Тоо	Өссөн дүнгээр
1	Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	11 214
		Сайн дурын даатгал	26 277
2	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон /Албан журам/	Шинээр	8 205
		Дахин	4 74
		Хугацаа сунгасан	18 283
3	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон /Сайн дур/	Шинээр	21 259
		Дахин	8 69
		Хугацаа сунгасан	15 194
4	Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал /воноор/	33,400,000.00 381,990,000.00
		Сайн дурын даатгал	150,700,524.00 1,420,247,057.94
		Нийт	236,204,524.00 56% 2,365,587,557.49 56,4%
5	3 болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	15,104,000.00 134,680,522.05
		Сайн дур	28,928,302.00 100,185,485.04
6	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт/вон/	Нэхэмжилсэн	30,730,640 195,220,820
		Олгосон	123,505,850 123,505,850
		Буцаан олголт авсан хүний тоо	25 25
7	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	129 3215
		Цахимаар	17 77
		Танхимаар	22 430

### **3. ТӨВӨӨС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ**

#### **3.1. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд**

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас Азийн орнуудын Хөдөлмөрийн атташе болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан албан хаагчдыг хамруулан 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцсон.

Олгогдоогүй цалин хөлстэй холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт, шийдвэрлэлтийн шатанд байгаа өргөдлийн жагсаалтыг гаргаж Консулын газарт илгээсэн ба олгогдоогүй цалин хөлсний маргаантай холбоотой аливаа асуудлыг түргэн шуурхай шийдвэрлүүлэх тал дээр дэмжлэг үзүүлж ажиллахыг суугаа орны холбогдох газарт Элчин сайдын яамны консулын газартай хамтран хүргүүлсэн.

БНСУ-ын The Bridge International байгууллагын хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад нутаг буцаж буй Монгол улсын иргэдэд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөр, бусад оронд хэрэгжүүлсэн төслийн мэдээллийг орчуулан цаашид хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар танилцуулж зөвлөгөө, чиглэл зааварчлага авахаар 76 хуудас бүхий материалыг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр ХХҮЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайд С.Сүхболд нарт албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

Улаан загалмай олон улсын байгууллагатай 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр уулзалт зохион байгуулж БНСУ-д оршин сууж буй Монгол иргэдэд дэмжлэг, тусламж үзүүлэх боломжийн талаар санал солилцов.

#### **3.2. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ**

Төвийн “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 19 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 19 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 133,349 хандалт авсан байна.

Ур чадвартай ажилчны визний асуудлаар “Е-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 547 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд 3 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

БНСУ-ын Өмнөд Чолла мужийн Гуанжу хотод оршин суугаа Монгол Улсын иргэдэд явуулын үйлчилгээ үзүүлж (2025.09.20), хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалтай холбоотой эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг 29 иргэнд хүргэж 80 гаруй гарын авлага, сурталчилгааны материалыг түгээв.

БНСУ-ын Чонжү хотноо (2025.10.04) зохион байгуулагдсан “Гэрээт иргэдийн намрын фестиваль”-ийн үеэр явуулын үйлчилгээ үзүүлж 20 иргэнд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалтай холбоотой хууль, эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгч 50 иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, төвийн танилцуулга сурталчилгааны материалыг хүргэв.

“MAMF-2025” Олон соёлт гадаад иргэдийн наадамд оролцож (2025.10.24-26) тухайн бүс нутгийн ойр орчмын хотуудад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын 22 иргэнд төвийн үйл ажиллагаа, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж,

хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, хөдөлмөрийн харилцаа болон нийгмийн даатгалын мэдээлэл агуулсан 130 гаруй гарын авлага тараан ажиллав.

Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран 3 иргэнд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээллийг хүргэв.

Солонгост ажиллаж амьдарч буй иргэдэд зориулсан сэтгэл зүйн ээлжит сургалтыг “Стресс биед хэрхэн нөлөөлдөг вэ” сэдвээр (2025.10.19 Ням гараг) анагаах ухааны магистр, ахлах зэргийн эмч П.Энх-Учралтай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад 34 иргэн хамрагдав.

“Гэр бүлийн харилцаа үнэт зүйл ба хамтын сэтгэл зүй” цахим сургалтыг Улаанбаатар их сургуулийн Гэр бүл судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэтэй хамтран зохион байгуулж, 14 иргэнийг хамруулсан.

“Шилжилт хөдөлгөөн ба сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт цахим сургалтыг (2025.09.28) зохион байгуулж, 38 иргэнийг хамруулав.

Бүсчилсэн хуваарийн дагуу хөдөлмөрийн гэрээт 20 ажилчинтай утсаар холбогдож, тэдний амьдрах орчин болон бусад нөхцөл байдлыг нь тодруулан хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

БНСУ-ын “Үндэсний техникийн мэргэшлийн тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын суурь хууль”, “Ажилтны ажлаас гарсны дараах тэтгэмжийг баталгаажуулах тухай хууль”-уудыг тус тус орчуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Олон улсын боловсрол солилцооны нийгэмлэгийн ерөнхийлөгч И Жун Ёл болон тус нийгэмлэгийн судалгааны хүрээлэнгийн захирал Жан Мин Сон нартай уулзалт зохион байгуулж (2025.09.24) Монгол хүүхдүүдэд хичээлийн дараах боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх, Монгол хэл, өв соёлыг хадгалан үлдэх, Монгол цэцэрлэг байгуулахад туслалцаа үзүүлэх зэрэг чиглэлийн хүрээнд хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.

Төвийн дарга Б.Жаргалмаа, БНСУ дахь Монгол оюутны холбооны тэргүүн Ш.Шинэмерөнтэй уулзаж, БНСУ-д суралцаж буй оюутан, залуучуудад нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцаа, сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад шаардлагатай мэдээллийг тогтмол, хүртээмжтэй хүргэх боломжийн талаар харилцан санал солилцов. Тус төвийн төлөөллийг Сөүл дэх Монгол оюутны холбооны долоо хоног бүр зохион байгуулагддаг уулзалтад оролцуулж, оюутан залууст мэргэжлийн мэдээлэл, зөвлөгөө өгч хамтран ажиллахаар тогтов.

Төвийн нийт албан хаагчдыг “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт (2025.10.15), Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим сургалт (2025.10.16), “Ажлын байрны үйлчилгээний стандарт” сэдэвт сургалт (2025.10.22)-д тус тус хамруулсан.

--- оОо ---